



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022-02-01

Дугаар: А/54

Эрдэнэт

**Бэлэн байдлыг хангах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3.2, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1, 9 дүгээр зүйлийн 9.17 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын омикрон хувилбартай тэмцэх болон бусад эмнэлгийн тусламж үйлчилгээний хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Өрхийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүд 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 02 дугаар сарын 06-ны өдрийг дуустал хугацаанд бэлэн байдалд ажиллаж, гүйцэтгэх ажлын төлөвлөлтийг нэгдүгээр, ажиллах албан хаагчдын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эрүүл мэндийн болон Коронавируст халдвар (Ковид-19)-ын тусламж үйлчилгээг шатлалын дагуу шуурхай үзүүлэх, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, жирэмсний болон амаржсаны хяналтад байгаа эхчүүд, нярай хүүхэд, архаг суурь өвчтэй иргэдэд хяналт тавьж, нийтийг хамарсан осол гэмтэл, хордлого, хүн малын халдварт өвчин болон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээллийг цаг алдалгүй аймгийн Шуурхай штабт мэдээлэн, холбогдох арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Ц.Наран-Эрдэнэ), Мал эмнэлгийн газар (П.Эрдэнэжаргал), Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын дарга, Өрхийн болон хувийн эмнэлгийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Бумансор нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ